

МОНГОЛ УЛСЫН
ДИПЛОМАТ АЛБАНЫ ОИД ЗОРИУЛАВ.

ХАМЖАХ
Хятад
байда
Хятад
Энэтх
улсын
Пакис
Солон
бодло
Энэтхэ

- 732 -



АЛТАН АРГАМЖ

ХХОО 互信



МОНГОЛ ЭЛЧ
НАРЫН ДУРСАМЖ

2009 8/16

УЛААНБААТАР, 1996 он

Оршил үг

ГАРЧИГ

Оршил үг	3
1. Д.Авгаанринчин	4
2. Б.Буд	8
3. Т.Гэндэн	17
4. П.Дармаа	28
5. Бу.Дашцэрэн,	
Ц.Дэмиддагва	42
6. Ц.Дэмиддагва	48
7. М.Дугэрсүрэн	57
8. Д.Ёндон	70
9. Д.Лувсанринчин	82
10. Б.Цэцэгдорж	90
11. Л.Ринчин	110
12. С.Сосорбарам	
Гадаад харилцааны албанд	119
13. Б.Цэдэн-Иш	
Монголын тусгаар тогтнол, хэл	138
Хэлтсүүдийн асуудалд	146
14. П.Шалдарсүрэн	
Дипломатчийн дурсамж сэтгэгдэл	154
15. Д.Эрдэмбилэг	
Хэлбетикийн хэвлэлийд өнгөрүүлсэн	
жилүүд	

Монгол Улсын дипломат алба олон зууны түүхэн уламжлалтай. Монголд төрт ёс үүсэн тогтсоноос хойшхи түүхийн эхдрээ нугаагай янз бүрийн үед төр, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн халдашгүй дархан байдлыг сахин хамгаалахын төлөө шударга үйлсэд улс төрийн өндөр мэдэрмж, холч мэргэн ухаанаар хүчин зүтгэж явсан хүмүүс олон бий. Тэдний заримынх нь дурдмал урьд өмнө нийтлэгдэж байсан. Энэ удаа бид нэгэн цагт монгол төрийнхөө алтан аргамжийг бэхэлж явсан зарим ахмад дипломатч нарын дурсамж сэтгэгдлээс уншигч олон та бүхэнд толиглуулж байна. Эл бяцхан номыг Монгол Улсын дипломат албаны ойд зориулан хэвлүүлж байгаа юм. "Алтан аргамж" номыг 1991 онд хэвлүүлсэн "Ертөнцийн чихнээ..." номын үргэлжлэл, дэд дэвтэр гэж ойлгож болно. Энэхүү дурсамжийн өгүүлгүүдэд тухайн хүний хувийн үзэл бодол илэрхийлэгдэж буйг хүндэтгэн үзэж, зөвхөн хэл, найруулгын шинжтэй бага сага засвар хийх авдлаа. Ахмад дипломатч нарын маань дурсамж цаашид ч хэвлэгдэн гарч байх нь дамжиггүй.

Энэ номонд дурсамжаа бичсэн ахмадууд тухайн цагт Монгол Улсын гадаад бодлогыг хэрэгжүүлж, хоёр болон олон талын харилцааг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан, эх орноо хилийн чанадад нэр төртэй төлөөлж байсан элч нар гэдгийг эдүгээ тус улсын гадаад харилцааны албанд ажиллаж буй хэн бүхэн мэднэ. Иймээс тэдний зүтгэж явсан цаг үеийн онцлог, ажлын туршлага, элдэв сонин тохиолдол зэрэг нь хойч үеийнхэнд сонирхолтой агаад суртамжтай ч байж болох юм гэсэн санаанаас үүдэн энэхүү дурсамжийн эмхтгэлийг Гадаад харилцааны яамны төв аппаратын дэргэдэх ахмадын хороотой хамтран эрхлэн гаргаваа.

Г.Жаргалсайхан

432

Д.Агваанринчин
Дэд итгэмжлэг

ДУРСАМЖ

НЭГ. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСАД АЖИЛЛАСАН МИНЬ

Миний бие БНМАУ-аас БНХАУ-д суугаа ЭСЯ-нд 1953 оны 5 дугаар сараас 1956 оны 6 дугаар сарыг дуустал нягтлан бодогчоор ажилласан юм. Тэр үед хоёр улсын харилцаа ид найрсгал, нам, засгийн төлөөлөгчид айлчлах, урлагийн олон хүний бүрэлдэхүүнтэй хэсгүүд солилцох, оюутан харилцан суралцуулах, манай ажилчид очиж үйлдвэрийн дэдлага хийх, хятад ажилчид Монголд ирж барилга барьж, зам, гүүр тавьж байсныг бид бүгд мэднэ. Би нүүдлийн кино аппаратаар кино гаргаж сураад өөрийн ажилчид, бусад элчин сайдын яамныханд зориулан кино коктейль хийдэг байв.

Харилцаа сайн байх үед манай урлагийн хэсэг Хятадад очиход олон хотоор явуулж тоглуулан, очсон хот бүрийн хэвлэлд сайн сайхан материал бичигдэж байсны дотор Цогзолмааг Азийн мөнгөн хонх гэж бичсэн нь ч бий.

Мөн манай үйлдвэр, аж ахуйн хүмүүс Бээжин болон хятадын бусад хотод дэдлага хийдэг байлаа. Эдний дотроос манай шаазан ваар, хивсний үйлдвэр, махкомбинатаас очсон хүмүүс буцаж ирээд шинэ зүйл санаачилдаг болсны гадна манай улсын савангийн үйлдвэрийг анх бий болгосон юм. Шаазангийн үйлдвэрээс Дагвадорж, хивснийхээс Цэмбэл, махкомбинатаас Дуламсүрэн нар очиж байсан.

Манай ЭСЯ-нд зохиогддог төрөл бүрийн арга хэмжээнд хятадын талаас уригдсан хүн бүр оролцон харилцан, элэгсэг дотно үг хэлдэг байсан бол Хятадын соёлын хувьсгалын үед хэлтэс, нийгэмлэгийн орлогч дарга тэргүүтэй 20-30 хүн хожимдож ирээд харилцан үг хэлж баяр хүргэлцэх байтугай хагас цагийн өмнө арга хэмжээг хаян явдаг болсон бөгөөд тэр өдөр нь хятадын төв хэвлэлд ёс шиг манай улсыг дайрч зухсан материалыг нийтэлдэг байв.

1954 онд би хэдийгээр жолоочийн ажил хийгээгүй боловч зардал хэмнэх үүднээс Улаанбаатар-Бээжингийн хооронд суудлын машин жолоодон 2 удаа явж, машин солих ба тэнд ажиллахаар очсон Буянтын Дашцэрэнг авч өвөр монгол айлд буудаллан зочлуулж явлаа. Энэ нь тэр үеийн харилцаа сайн байсны бас нэг илрэл юм. Харин 1964 онд мөн нэг машин аваад Улаанбаатараас явах гэтэл хятадын тал сар илүү хүлээлгээд зөвшөөрөөгүй юм.

Миний бие 1963 оны 3 дугаар сараас 1968 он хүртэл Бээжин дэх

ЭСЯ-нд ёслол хариуцсан атташе, на-бо-гоор дахин очиж ажиллах үед БНХАУ, социалист орнуудын харилцаа хэвийн биш болсон юм. Хятадад суралцаж байсан тэдгээр орны оюутнуудыг хятадын талын шаардлагаар эх оронд нь буцааж, харин тэнд хоригдож байсан манай оюутан Насанжав, Дийдэнцэцэг нар үлдсэн болно. Түүгээр ч барахгүй хятадын дэглүйчүүд Зөвлөлтийн ЭСЯ-ыг олон сар, хоногоор довтлон бүсэлж хэвийн ажиллагааг нь бүрэн алдагдуулсан тул зөвлөлтийн тал тэнд байгуулсан сургуулиа хааж эд хогшлоо өөрийн онцгоор буцааж тээвэрлэсэн юм. Тэр бүлийн хүмүүсээ ч нутаг буцаасан. Зөвлөлтийн ЭСЯ-ны машин хүрэлцэхгүй, манайхаас машинаар туслахыг хүссэн учир би өөрийн ЭСЯ-ны автобусыг жолоодон ганцаар тэдний юмнаас ачилцаж байсан билээ.

1967 оны 8 дугаар сарын 9-ний өдөр манай элчин сайдын 17000-хан км яваад байсан "Чайка" машинтай жолооч Даш-Онолтыг худалдааны гудамжинд баригдлаа гэдэг мэдээ аваад би машинаа жолоодон орчуулагч Ө.Дашдоржтой тэнд очиход хятадууд бид хоёрыг мөн баривчилж, үс зулгаан чирсэн юм. Тэд Даш-Онолтод цаасан малгай өмсгөөд, машиныг шатааж байхыг би харж зогслоо. Манай жолоочийг шоронд хорьж байгаад 10 гаруй хоногийн дараа "танай жолоочийг эх орноосоо хөөлөө" хэмээн ЭСЯ-нд утсаар мэдэгдээд, биднийг галт тэрэгний буудал дээр очиж түүнийг үлдэхийг хориглож байв. Энэ баривчилгаанаас Дашдорж бид хоёрыг хятадын зэргийлэхийн хүмүүс чөлөөлсөн болно. 1967 оны 9 дүгээр сарын 3-ны 14 цагаас эхлэн хятадын дэглүй залуучууд Элчин сайдын Яамны үүдэнд жагсан, 10 орчим хүн ЭСЯ-ны байрны хашааг дайран орж конторын байшингийн гадна, дотор хананд манай нам, засгийн эсрэг улиг болсон хараалын үгээ хар будгаар бичиж амжаад хятадын цагдаагийн шаардлагаар хашааны гадна гарсан юм.

Энэ өдрөөс эхлэн самуун дэгдээгчид Элчин сайдын Яамыг бүслэн жагсаж хашаан дээр дуу өсгөгч 10 шахмыг байрлуулан 10 гаруй хоног өдөр шөнөгүй манай улс болон Зөвлөлтийн эсрэг бахиралдан, унтаж амрах, ажиллах нөхцөлгүй болгож, мод, чулуу, төмс ногоо, будагтай лонх шидлэн контор, сууцны цонхнуудыг хагачиж байлаа. Мөн жолооч Даш-Онолтыг дүрслэн өвсөн чучил хийж, түүний машин дотор байсан хувцсыг өмсгөн хашааны хаалган дээр өндөрт өлгөөд хараалын үг, үсэгтэй хуудсаар хашааг бүрхэн нааж, нэг ч хүн оруулж гаргахгүй хорьсноор барахгүй өвчтэй хүүхдэд эмнэлгийн тусламж үзүүлэх бололцоо олгохгүй байв.

Манай байр Ардчилсан Германы худалдааны төлөөлөгчийн газрын контортой хамар хашаанд байсны ачаар бидний хоол ундыг социалист

орныхон бэлтгэж тэнд авчраад шөнө хашаан дээгүүр өгдөг байсан бөгөөд Болгарын ЭСЯ-ны нарийн бичгийн дарга, эмч Мальчанов мөн замаар ирж өвчтэй хүүхдийг эмчлэн эдгээсэн юм. Жагсагчид манай улсыг атаат дайснаа хэмээн занаж, "Та нар элчин сайдаа баривчлаад бидэнд өг, бид хийх гэсэнээ хийж чаддаг хүмүүс шүү" гэж цаг минут тогтоон шаардаж байгаад нэг шөнө дуу хураагч, гэрэл зургийн аппараттай хүмүүс конторт дайран орж ирээд, эсэргүүцлээ илэрхийлсэн хүмүүсийн бичгийг элчин сайдад чинь гардуулан өгнө гэж тэвэр дүүрэн цаас тулгахад элчин сайд Д.Цэвэгмид аваагүй. Тэд конторын үүдний хонгилд хашигчин загнаж элдвээр авирлан байж бичиг цаасаа өгсөн дүр үзүүлээд гарсныг тод санаж байна. Энэ үеэр тус ЭСЯ-нд ажилладаг 10 шахам хятад хүн биднийг эсэргүүцэн ажил хаясан юм. Тэд жагсаал тарсны маргааш нэдтай хэлэлцээ хийн тохиролцоод ажилдаа орцгоосон. Ийм байдлын улмаас хүүхдүүд сүрэг сургуульгүй, эмэгтэйчүүд ажиллаж амьдрах нөхцөлгүй боллоо. Улаанбаатар руу буцаж зөвхөн ажилтай эрэгтэйчүүд үлдэх билээ. Үүнээс хойш хэд хоногийн дараа манай зэргэлдээ байсан Английн ЭСЯ-ыг мөн 2 хоног бүсэлж байгаад хоёр давхар байшинг нь шатааж, зарим хүүхэд, эмэгтэйчүүдийг нь зэрлэгээр доромжилсон. Энэ үе бол Монгол, Хятад хоёр улсын харилцаа муудахын дээр цэт хүрч элчин сайд Д.Цэвэгмидийг Бээжингээс бүрмөсөн буцаахад 1958 оноос манайд ирж улсын их сургуульд сурч төгсөөд Улаанбаатарт Элчин сайдын Яамандаа ажиллаж байгаад буцаж очсон суулд манай улсад элчин сайд байсан Жан Дуйлэн, түүний гэргий Үнэ нар Бээжингийн галт тэрэгний буудал дээр "Монголын засварлаг үзэлтний нохой толгойг хага цохёе, зөвлөлтийн ревизионистүүд, сөнөгүтэй" хэмээн хашгираад зогсож байж билээ. Ийм хүмүүст манай дахин дахин ирэхийг зөвшөөрсөөр байдаг нь надад таатай бил санагддаг юм.

Хятадын ГЯД-наас дипломтуст зориулан зохиосон хаврыг аяллаас манай түр хамаарагч Г.Багаа, атташе О.Адьяа нарыг хөөх буцаах зэргээр буудуулж авирлаж байснаар барахгүй ЭСЯ-ны нарийн бичгийн дарга Ч.Далай бид хоёрыг ГЯД нь дуудаж аваачаад ярилцсаны дараа биднийг явуулахгүй хаалганы үүдэнд гар гараасаа барьж, хорин зогсож байсан юм. Тэд бол Хятадын ГЯД-ны Азийн болон консулын газрын манайхыг хариуцсан дипломат хүмүүс шүү дээ. Дээрх байдлаас дүгнэлт хийхэд хоёр улсын харилцаа ямар хэмжээнд хүрсэн, Хятадын "ату их удирдагч" Мао Зэ-дунь зохион байгуулсан соёлын хувьсгал гэгч ямар хувьсгал байсан нь тодорхой 1968 онд манай ЭСЯ-ны орон тоог цөөрүүлэх болсон учир би

дүгээр сарын 1-нд буцаж ирсэн, харин дараа нь Москвад суугаа ЭСЯ-нд үйлчлэгч-жолоочоор ажилла, явахгүй гэвэл өөрөө ажлаа олоорой гэсэн утгатай ГЯД-ны удирдлагын эвлүйхэн тулгалаар 1970-74 онд Москвад ажилласан юм. Тэнд ажил хүнд болохоос биш сэтгэл санаа маш тайван байж билээ. Москвагаас буцаж ирээд ГЯД-нд аж ахуй-үйлчилгээний хэлтсийн дарга, үйлчлэх товчооны орлогч даргаар ажиллаж байлаа.

ХОЁР. БНАЛАУ-Д ЭЛЧИН САЙДЫН ЯАМ БАЙГУУЛСАН ТУХАЙ

Миний бие 1976-1979 онд Вьентьянд шинээр байгуулагдсан ЭСЯ-нд аж ахуйн эрхлэгч-жолоочоор ажилласан юм. Очсон дарууд байр олдохгүйн улмаас хагас жил зочид буудал, түр байраар хэсгүүлэн явж байгаад хотын төвд 2 жижиг байр авч их засвар хийлгээд бүх зүйлээ Тайландын нутгаас бэлэн валютгаар худалдан авч нэг жилд Элчин сайдын Яам шиг яам байгуулсан гэж сэтгэл хангалуун байдаг билээ.

Тэр үед хоёр улсын харилцаа маш сайн, ГЯД-ны төлөөлөгчид айлчлан, урлагийн хэсгүүд солилцож, Лаост хонины аж ахуй, хүн эмнэлгийн салбар байгуулах, оюутны нь ирүүлж сургах зэргээр хамтын ажиллагаа хөгжиж байлаа. Мөн Лаос-Монголын найрамдлын нийгэмлэг байгуулагдан анхны дарга нь Соёлын Яамны сайд Сисан Сисана гэдэг хүн болж байв. Ажлын эдгээр сайн эхлэл нь анхны элчин сайд Пунцагийн Цэрэнцоодолын сайн зохион байгуулж ажилласны үр дүн гэж би хувьдаа боддог. Манай жүжигчдийг Лаост очиход Сисан Сисана хоёр орны найрамдлын тухай дуу зохиолгон дуулуулж байсныг санаж байна.

Миний ажиллах хугацаанд Лаост дайны байдал дуусаагүй, улс байгуулагдаад хагас жил болж байсан бөгөөд Тайландын талаас Меконго мөрний цаанаас цаг үргэлж буудан голын эргийн дагуух байшин барилгыг сүйтгэн цэрэг, энгийн иргэдийг хөнөөж байв. Мөн хилийн зарим газар аль аль талаасаа байнга буудалцаж байсан юм.

Лаосын ГЯД-наас дипломтуст зориулан анх удаа зохиосон аялалд гадаадын ЭСЯ-ныхныг тус тусын нь машинаар явуулсан юм. Нэг хотын дундуур өнгөрч захад нь гарч явтал манай машины урд шил гэнэт тас хийн хагарч зам харагдахгүй болсонд дэргэд сууж явсан Саянлхам замын хажуугийн модон дотроос хүн буудсан байх гэж байв. Буудсан гэдэг нь пөмбөгөр шилний нэг захаас нөгөө зах руу нэвт нүх гарсанд байв. Үүнийг лаосын талын хамгаалалтын хүмүүс үзээд ямар дүгнэлт өгснөө бидэнд хэлээгүй өнгөрсөн юм. Түүнээс хойш лаосын

тал иймэрхүү аялал зохиогоогүй юмдаг.

Би дээр дурдсан 4 ЭСЯ-нд нийт 5 удаа ажиллахдаа 9 элчин сайдын нүүр үзэж, Лаоссоос ирээд ГЯД-ны ДБУААГ-ын газар, архивт ажиллаж байгаад 1986 оны 10 дугаар сард тэтгэвэрт гарсан юм.

Эх орондоо цэрэгт явж үзээгүй намайг ийм дайн, самуунтай орнуудад ажиллуулсан тэсвэр, хатуужилд сурган хүмүүжүүлж, ийнхүү дурсамж бичихэд хүргэсэн ГЯД-ны хамт олондоо баярлаж байна.

Б.Буд

Тэргүү шаглар

ГАДААД ХАРИЛЦААНД 32 ЖИЛ

Чадах чинээгээр улсад алба хаших нь миний үүрэг гэж бодож явсан. Нам, улс, олон нийтийн байгууллагад 40 гаруй жил ажилласны 32 жилд нь Монгол Улсын Гадаад харилцааны төв болон хилийн чанад дахь байгууллагад алба хашиж, Анх би дипломат алба хашина гэж бодож байсангүй. Учир нь энэ ажилд шаардагдах зохих боловсрол, мэргэжил надад байгаагүй. Тохиролдож байсан хөтгэй явдал, өдрийн тэмдэглэл аятай юмаа дор өгүүлэх зүйлд нурушиж бичье гэж бодсоогүй.

Монгол Улсын гадаад харилцааны байгууллагад миний алба хашсан үе (1960-1992 он) Монгол Улс гадаад бодлого, харилцаандаа тухайн үед баримталж ирсэн онол, зарчимтай холбоотойг хэн бүхэн ойлгох учир нуруших хэрэггүй биз.

1960 оны 7 дугаар сард намайг Монгол Улсын гадаад харилцааны хилийн чанад дахь байгууллагад ажиллуулах шийдвэр гарч ийнхүү дипломат гэдэг нэр хүндтэй, өндөр хариуцлага бүхий албанд шилжсэнээ оршил болгоё.

Дипломат атташегаас элчин сайд хүртэл албан тушаалд 5 удаагийн томилолтоор 13 жил хатас гадаад улсуудад ажилласан маань дипломат албанд суралцах амьдралын их сургууль байлаа.

Африкийн баруун эрэгт орших Гвиней улсад Монгол Улсын ЭСЯ анх 1960 оны 8 дугаар сарын эхээр байгуулагдаж түүнд атташегаар ажиллах үүрэг ногдсон. Прагаас Конакри хүрэх 19 цагийн нислэгийн замд францаар 10 хүртэл тоо, 5 үг цээжилж очсон билээ. Төвд бэлтгэл хийгээгүй, харин газар дээрээ очоод дипломат баримт бичиг боловсруулах, хэлэлцээ, яриа хийх, ёс горимд суралцах ажил эхэлсэн. Энэ бүхэнд манай гадаад харилцааны боловсрол, дадлага бүхий дипломат агсан П.Цэрэнцоодол цаг ямагт тусалж, зааж хэлж өгдөг байсан.

Тэнд хоёр жил ажиллахдаа ямагт халуун дулаан байдаг улс орон, хар арьстны талаар анхны мэдэгдэхүүн авсан. 60-аад он бол колонийн систем задран унаж, Ази, Африк, Латин Америкийн олон орон эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж шинэ шинэ улсууд буй болж байсан үе. Харин би колоничлол гэдгийг сонссоноос биш нүдээр үзээгүй байв.

Колонийн дарлал мөлжлөгт олон арав, зуун жилээр нухлагдсан улс, ард түмэн түүний уршгийг хэдхэн жилд аригладаг зүйл биш юм даа гэдгийг мэдэрсэн. Хүн ардын нь амьдрал дорой, боловсрол бага, улсын эдийн засгийн хоцрогдол зэрэг олон зүйлийг нүдээрээ харсны хувьд баттай хэлж байна. Эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж авсандаа туйлаас баяртай байгаа хүн ардыг нь ч харсан.

Африкийн улс орон ард түмэн тэр үед Монгол Улсыг мэдэхгүй байсан гэж хэлэхэд ташаа болохгүй байх. Монгол Улсын хувьд гэвэл африкийн ард түмний тусгаар тогтнолыг нь дэмжих, найрсаг харилцаатай байхыг эрмэлзэж дипломат харилцаа тогтоож эхэлсэн. Монгол Улсын хувьд ч тэдний дэмжлэг чухал байсан нь ойлгомжтой.

Гвинейн Ерөнхийлөгч Секу Туре 1960 оны 8 дугаар сард Монголд албан ёсны айлчлал хийсэн нь Африк тивийн улсуудын дотроос Монголд айлчилсан анхны элч төлөөлөгч юм.

1960 оны сүүлчээр Мали улсын Ерөнхийлөгч Модибо Кейта Гвинейд айлчлах үед манай түр хамаарагч П.Цэрэнцоодол түүнтэй уулзаж, хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоохоор ярилцсаныг тодорхой санаж байна. Тэр өдөр түр хамаарагч маань Гвинейн Ерөнхийлөгч Секу Туре, Малийн Ерөнхийлөгч Модибо Кейта хоёрын дунд суугаад тэдэнтэй ярилцаж байгааг нь харахад бахтай байж билээ.

1980-аад оны эхээр Секу Туре Францад айлчлах үед болсон нэгэн хүлээн авалт дээр түүнтэй уулзах завшаан надад тохиосон. Тэр Монголд айлчилснаа дурсаж байдаг гэж яриада монголын ард түмэнд сайн сайхныг ерөөж байсныг энэ ялдамд тэмдэглэе.

Элчин сайдын Яам байгуулахад хогийн шүүр, хувин савнаас эхлээд газар, орон сууц, унаа хүртэл юм юм л хэрэгтэй юм даа гэдгийг Конжарид ЭСЯ байгуулахад оролцсон учир мэдэх болсон. Энэ албанд шинээр ажиллаж байсан надад мэдэхгүйн бэрхшээл их тохиолдож байснаа дурдъя. Хамгийн бэрх зүйл гэвэл, халуун оронд байдаг өвчнөөс сэргийлэх явдал. Энэ талаар манай улс ч, тэнд ажиллахаар анх очсон бидэнд ч туршлага байсангүй. Тийм өвчний нэг-малеригаар өвчилсний уршаар биднээс хэд хэд маань сүүлд өөд болсныг харамсаж дурдъя.